


ГЕПАТИТИЙН Б ВИРУСИЙН ХАЛДВАРЫГ ЭРТ ИЛРҮҮЛЭХ НЬ ЧУХАЛ

Та болон таны гэр бүлийн гишүүд Гепатитийн Б вирусийн (ГБВ) халдварт илрүүлэх шинжилгээнд хамрагдах нь цаашдын хүндэрээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой.



ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДААРАЙ

Эмчээсээ дараах 3 төрлийн ГБВ-ийн цусны шинжилгээний талаар лавлаарай:

ГБВ-ийн дархлаа тогтоцыг гадаргуугийн эсрэгтөрөгч (HBsAg):

ГБВ-ийн халдвартайг илэрхийлэх анхдагч үзүүлэлт ба ГБВ-ийн цочмог ба архаг халдвартын аль алинд нь цусанд илэрдэг.

ГБВ-ийн гадаргуугийн эсрэгтөрөгчийн эсрэг эсрэгбие (anti-HBs):

ГБВ-ийн халдвараас хамгаалах дархлаатай эсэхийг илтгэнэ.

В гепатитийн цөмийн эсрэгтөрөгчийн нийт эсрэгбие (anti-HBc):

Шинжилгээний хариу эерэг байх нь та өмнө нь ГБВ-ийн халдварт өртөж байсан эсвэл одоо ГБВ-ийн халдвартай эсэхийг харуулна.

ГБВ-ИЙН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТАНД ХАМРАГДААРАЙ

Хэрэв таны өгсөн 3 төрлийн шинжилгээ сөрөг гарвал ГБВ-ийн эсрэг дархлаа тогтоогүйг илтгэх тул ГБВ-ийн эсрэг вакцинд хамрагдаарай. Мөн хүүхдээ вакцинд хамруулна уу. ГБВ-ийн эсрэг 3 тун вакциныг 6 сарын дотор тариулсаннаар та ГБВ-ийн халдвараас насан туршдаа хамгаалгдана. Насанд хүрсэн хүн ГБВ-ийн 2 тун вакциныг 1 сарын дотор тариулна. ГБВ-ийн эсрэг вакцин нь ГБВ-ийн шалтгаантай элэгний хатуурал, хавдараас сэргийлдэг тул уг вакциныг ДЭМБ хорт хавдрын эсрэг анхны вакцин хэмээн нэрлэдэг.

ГБВ-ИЙН ЭСРЭГ ХАМТДАА



ГБВ-ийн эсрэг Jade Ribbon, JoinJade-ийн урианд нэгдэгтүн, дэлхий даяараа ГБВ, элэгний хорт хавдрын эсрэг дуу хоолойгоо нэгтгэн тэмцье.



Стэнфордын анагаах ухааны их сургуулийн дэргэдэх Азийн элэгний төв

780 Welch Road, CJ 130
Palo Alto, CA 94304
Tel: 888.311.3331
Fax: 650.736.8001
liver.stanford.edu
[#JOINJADE](#)

MONGOLIAN EDITION
© 2024 ASIAN LIVER CENTER

KNOW HBV



Гепатитийн Б вирус,
элэгний хавдрын
талаар мэдвэл зохих зүйлс

 ASIAN LIVER CENTER
at Stanford University

 Stanford
MEDICINE

ГБВ-ИЙН ХАЛДВАР



Гепатитийн Б вирус нь элэгний архаг халдвар, хатуурал, хавдрын гол шалтгаан болж байна.

Ихэнх хүмүүс ГБВ-ийн халдвар авсан эсэхээ мэддэггүй.

ГБВ-ийн халдвартай 4-н хүн тутмын 1 нь элэгний хорт хавдар, дутагдлын улмаас нас бардаг, тиймээс эрт оношолж удаан хугацааны туршид эмчийн хяналтад, тохиromжтой эмчилгээг хийлгэснээр уг хүндрэлээс сэргийлэх боломжтой.

ЭМНЭЛЗҮЙН ШИНЖ ТЭМДЭГГҮЙ, ДАЛД ХЭЛБЭРЭЭР ӨВДӨН, ВИРУС ТЭЭГЧ БОЛДОГ

ГБВ-ийн архаг халдварын үед эмнэлзүйн шинж тэмдэг илэрдэггүй нь их аюултай, элэгний үйл ажиллагааны шинжилгээ хэвийн гарч болохыг анхаарах хэрэгтэй. Эмнэлзүйд ядарч сульдах, нүд арьс салст шарлах, дотор муухайрах, хэвлийгээр өвдөх, хоолонд дургүй болох гэх мэт шинж тэмдэг илэрдэг.

ГБВ-ИЙН ХАЛДВАР ДАМЖИХ ЗАМ



Эхээс урагт дамжих халдвар

ГБВ-ийн халдвартай эхээс хүүхдэд халдвар дамжих нь архаг Б вируст гепатит үүсэх гол шалтгаан болдог.



Цусаар дамжин халдварлах

ГБВ-ийн халдвар нь халдвартай хүний цусаар дамжин халдварлана. Үүнд:

- Арьс салстын бүрэн бүтэн байдал алдагдсан үед (чих цоолох, шивээс хийлгэх хэрэгсэлийг дахин хэрэглэх)
- Халдвартай хүний шүдний сойз, сахал, хумсны хутга хэрэглэх.
- Ариутгаагүй зүү тариур дахин хэрэглэх гэх мэт.



Бэлгийн замаар халдвар дамжих

ГБВ-ийн халдвартай хүнтэй хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсноор ГБВ-ийн халдвар дамжих эрсдэлтэй.

ГБВ НЬ УС, ХООЛ ХҮНСЭЭР ДАМЖИН ХАЛДВАРЛАДАГТҮЙ

ГБВ нь дор дурдсан замаар халдварлахгүй гэдгийг ойлгох нь чухал. Үүнд:

- Хоол хүнс хуваалцсанаар
- Аяга таваг, хоолны хэрэгсэл дундаа хэрэглэнээр

ГБВ-ийн халдвартай хүмүүсээс зайд барьж ажил, сургууль, өдөр тутмын идэвхтэй үйл ажиллагаанаас нь тусгаарлах ёсгүй.

ХЭРВЭЭ ТА ГБВ-ИЙН АРХАГ ХАЛДВАРТАЙ БОЛ ЮУГ АНХААРАХ ЁСТОЙ ВЭ?

АРХАГ ХАЛДВАРЫН ҮЕД АНХААРАХ ЗҮЙЛС

ГБВ-ийн архаг халдвартай бол дараах шинжилгээнд тогтмол хамрагдаарай.

Шинжилгээний давтамж	Шинжилгээ	Хяналт
6-н сар	ALT	Элэгний эсийн гэмтэл
	AFP	Элэгний хавдар вирусийн идэвхжил
1 жил	HBV DNA level	Элэгний хавдар
1 жил*	Ultrasound	

* Хэрвээ та элэгний хатуурлатай, таны гэр бүлд элэгний хорт хавдраар өвчилсөн хүн байсан бол нас харгалзахгүй 6 сар тутам эхо-д харуулах, элэгний хавдрын маркер болох АФП шинжилгээнд хамрагдаарай.

Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх нь эмчлэгдэх боломжийг нэмэгдүүлдэг.

ГБВ-ийн халдвар ээрэг илэрсэн үед мэргэжлийн эмчийн хяналтанд тогтмол байх

Гепатит ГБВ эмчлэх ямар ч арга байхгүй ч одоогийн санал болгож буй вирусын эсрэг эм нь (энтекавир/ тенофовир) элэгний хорт хавдар, элэгний дутагдалд хүргэдэг элэгний гэмтлийг эмчлэх ба гэмтлийг эдгээх үр дүнтэй байдаг.

Хорт хавдар болон бусад өвчний улмаас дархлаа дарангуяалах эмчилгээ хийлгэх буй өвчтөнүүдэд ГБВ-ийн халдвар дахин идэвхжихээс урьдчилан сэргийлэх, мөн ГБВ-ийн ДНХ-ийн түвшин 200,000 IU/ mL-ээс хэтэрсэн жирэмсэн эмэгтэйчүүдэд ГБВ-ийн халдвар эхээс урагт дамжихаас урьдчилан сэргийлэх зорилгоор вирусын эсрэг эмчилгээг зөвлөж байна.



Гепатит А вакцинд хамрагдаарай



Архины хэрэглээнээс татгалзах



Өөрийн хайртай хүмүүсээс хамгаалаарай

Таны гэр булийн гишүүд ГБВ-ийн эсрэг дархлаагүй, халдвар авч байгаагүй бол вакцинд хамруулаарай. Хэрэв та жирэмсэн бол хүүхдээ төрсөний дараах 12 цагийн дотор ГБВ-ийн эсрэг вакцин болон ГБВ-ийн эсрэг иммуноглобулин хоёрыг тариулж, вакцины бүрэн тунг товтолын дагуу хийлгээрэй. ГБВ-ийн эсрэг вакцин нь таны хүүхдийг халдвараас хамгаална.